



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/06

Модот

**Худалдан авах ажиллагаа зохион
байгуулах ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйл, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2.1, 48.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын 2.4 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 66 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр дотуур байрны хоол хүнс нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: О.Батбаяр - Засаг даргын тамгын

газрын төрийн сан, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичиг: Г.Золбоо - Ерөнхий боловсролын сургуулийн нярав

Гишүүн: Д.Пүрэвсүрэн - Цэцэрлэгийн нярав

2.Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажлыг хуулийн хүрээнд чанартай зохион байгуулж, зөвлөмж ирүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (О.Батбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ